



Монголын  
хөрөнгийн  
бирж

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2023



## АГУУЛГА

1	<b>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ</b>	x 4
2	<b>БИДНИЙ ТУХАЙ</b>	x5
	Монголын хөрөнгийн биржийн түүхэн товчоон	x7
3	<b>БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>	x9
	Газруудын чиг үүрэг	x9
	Удирдлагын баг	x10
	Хүний нөөц	x11
4	<b>КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>	x12
5	<b>КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ</b>	x12
6	<b>ТУЗ-ийн ТАНИЛЦУУЛГА</b>	x14
	ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ур чадвар	x15

	ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан	x16
	Мэдээллийн ил тод байдал	x17
<b>7</b>	<b>ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН</b>	x18
<b>8</b>	<b>ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ</b>	x19
<b>9</b>	<b>ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД</b>	x20
<b>10</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ</b>	x31
<b>11</b>	<b>УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ</b>	x38
<b>12</b>	<b>САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	x41
<b>13</b>	<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	x42
	Аудитын дүгнэлт	x43
	СТ4 тайлан /Аудитлагдсан/	x47

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр зуучлан хүргэж үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулах эрхэм зорилготой “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн тайлантай танилцаж буй эрхэм танд энэ өдрийн мэнд дэвшүүлэе.

“Монголын хөрөнгийн бирж” нь Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч хөгжих түүхэн нөхцөл бүрэлдсэн тэртээх 1991 оноос өнөөг хүртэл 32 жилийн турш үйл ажиллагаагаа өргөжүүлэн, санхүүгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэлттэй уялдуулж техник технологи, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, шинэ шатанд гаргахад идэвхийлэн ажиллаж байна.

2020-2023 онд цар тахлын дараах бизнес, эдийн засгийн сэргэлт эрчимжиж, хөрөнгийн зах зээлд оролцогч талуудын идэвх нэмэгдсэн. Тухайлбал, 2023 оны 4-р улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны гишүүн 51 компани, үнэт цаасны данс эзэмшигч 2.5 сая иргэн, 3000 гаруй идэвхтэй хөрөнгө оруулагчтайгаар 1, 2, 3-р ангилалд бүртгэгдсэн 173 хувьцаат компанийн нийт зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөгт хүрээд байна.

2020-2023 он Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 3 дахин өссөн томоохон эргэлтийн он жилүүд байлаа. Тухайлбал, Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell групп 2022 оны 9-р сард Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг 2023 оны 9 дүгээр сараас эхлэн FTSE Russell-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн ангилалд оруулахыг зөвшөөрсөн.

Мөн Улсын Их Хурлаас “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” 16 дугаар тогтоол, Засгийн газрын “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 244 дүгээр тогтоолоор Төрийн банк болон нэр бүхий 26 компанийн 34 хүртэл хувьд IPO хийж, нээлттэй аж ахуйн нэгж болгон олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод

байдлыг хангахаар шийдвэрлэсний дагуу 2022 оны 12 дугаар сарын 23-нд “Монголын хөрөнгийн бирж” нэмэлт хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, өдгөө нээлттэй компани болоод байна.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд системийн 5 банк болох Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк, Голомт банкууд нь 2023 оны 06 дугаар 30-ны өдрөөс өмнө нээлттэй компани болох үүргээ биелүүлж, олон нийтэд хувьцаагаа санал болгосноор нийт 446.79 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж үндэсний аж ахуйн нэгжүүдийн хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, өрийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүнүүдийг бүртгэн олон нийтэд санал болгож, 184.22 гаруй тэрбум төгрөгийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгууллаа.

Өдгөө Монголын хөрөнгийн бирж арилжааны системийн өргөтгөл шинэчлэл хийн, уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон өргөжлөө.

Хойшид гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдыг Монголын санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцох боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү үйл ажиллагаанд хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагч болон энэхүү тайлантай танилцаж буй эрхэм та бүхэнтэй бүхий л талаар хамтран ажиллахад таатай байх болно.

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх та бидний хамтын ажиллагаа улам төгөлдөржиж, улс орныхоо эдийн засгийн хөгжилд бодит үр дүнг үзүүлэн, хөгжлийн түүхээ болж өргөжин хөгжинө гэдэгт итгэл төгс байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил, хүртээмж өгөөж улам нэмэгдэж, хөгжлийн гарц өргөжин тэлэх болтугай!



Гүйцэтгэх захирал  
**Х.АЛТАЙ**

## БИДНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны нэгдүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулж, улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлснээр Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжилтийн түүхэн үе эхэлсэн юм.


Улмаар 1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд нийт 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, тэдгээрийн 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшүүлсэн.

Үүний дүнд Монгол Улсын нийт хүн амын 52 орчим хувь буюу 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болж байсан түүхтэй. Энэхүү үйл явц нь Монгол Улсын эдийн засгийн бүтцийг өөрчилж, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, өмч хувьчлалыг өргөн хүрээнд зохион байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Монголын хөрөнгийн бирж олон улсад нэр хүнд бүхий "Лондонгийн хөрөнгийн бирж" групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник технологи, дэд бүтцийн хувьд хөгжлийн шинэ түвшинд хүрээд байна.

Үүгээр зогсохгүй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд шинэчилсний үр дүнд хууль эрхзүйн орчин ч олон улсын жишигт хүрч хөгжлөө.

Хууль эрх зүйн таатай орчин бий болсноор гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоодын хөрөнгийн биржид үнэт цаасны давхар бүртгэл хийлгэх боломж бүрдэж, 2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр анхны давхар бүртгэл хийсэн.



Мөн хадгаламжийн бичиг, үнэт цаасны номинал болон бенефициар өмчлөл, кастодиан зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээ хөрөнгийн зах зээлд шинээр нэвтэрсэн.

2020 онд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимыг амжилттай нэвтрүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж нь 1995 оны наймдугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээс хойш 2021 оны эцсийн байдлаар нийт 4.75 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжааг зохион байгуулж, 30 жилийнхээ ойг түүхэн дээд амжилт, голлох үзүүлэлтүүдийн онцгой өсөлтөөр үдсэн юм.

Түүнчлэн 2021 оны эхэнд Банкны тухай хууль шинэчлэгдэж, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжин, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зах зээлд олон улсын стандарт нэвтрүүлэх зорилгоор, дэлхийн шилдэг хөрөнгийн биржийн нэг Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааг эхлүүлсэн.

2022 онд Монголын Хөрөнгийн Бирж төдийгүй хөрөнгийн зах зээлд онцгой нөлөө үзүүлэх хэд хэдэн үйл явц өрнөсөн. Тухайлбал, олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч "FTSE Russell" группээс 2022 оны 9-р сарын 29-ний өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн "Хөгжиж буй" (Frontier Market) зах зээлийн зэрэглэлийн шалгуурыг бүрэн хангасан тул 2023 оны 9 дүгээр сараас эхлэн тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд, засаглал сайжруулах чиглэлд төрийн өмчит компаниудаас нэн тэргүүнд Монголын Хөрөнгийн Биржийг олон нийтэд нээлттэй компани болгох шийдвэрийг гаргаж, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгон, олон нийтийн өмчийн оролцоотой компани болоод байна. Ингэснээр "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц шинэчлэгдэж, олон нийтийн хараа хяналт, ашигт ажиллагаа, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын зах зээлд татах боломжийг нээх ХӨГЖЛИЙН ШИНЭ ТҮҮХИЙГ эхлүүлсэн.

Үүний зэрэгцээ дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөг болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 16.87 хувьд хүрээд байна.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд системийн 5 банк болох Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк, Голомт банкууд 2023 оны 06 дугаар 30-ны өдрөөс өмнө нээлттэй компани болох үүргээ биелүүлж, олон нийтэд хувьцаагаа санал болгосноор нийт 446.79 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Түүнчлэн үндэсний аж ахуйн нэгжүүдийн хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, өрийн хэрэгсэл зэрэг бүтээгдэхүүнүүдийг бүртгэн олон нийтэд санал болгож, 184.22 тэрбум төгрөгийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгууллаа.

Улсын Их Хурлаас "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль" баталж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос "Монголын хөрөнгийн бирж" ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор Монгол Улсад анхны уул уурхайн бүтээгдэхүүний бирж үүссэн түүхэн үйл явц өрнөж байна.

Энэхүү үйл явцтай холбогдуулан МХБ арилжааны системийн шинэчлэлт хийн, үйл ажиллагаагаа өргөжүүлэв. Мөн МХБ-ээр арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны үнийн мэдээллийг эх сурвалж болгон "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр" /AMHAT/ тооцдог боллоо. МХБ-ээр дамжин экспортод гарах уул уурхайн бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдэж төмрийн баяжмал арилжаалж эхэлсэн бол манай хамт олон 2024 онд зэс болон бусад нэр төрлийн бүтээгдэхүүн арилжаалах бэлтгэл ажлыг хангаж байна.

2023 онд Монголын хөрөнгийн зах зээлийг гадаад улсуудад сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр БНСУ, Хонконг, БНХАУ улсуудад үйл ажиллагааг зохион байгуулж, Будапештын хөрөнгийн бирж, Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Бид дотооддоо "Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт"-ыг сар бүр тогтмол, Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөгийг зах зээлд оролцогч бусад байгууллагуудтай хамтран хугацаа товлон зохион байгуулж иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр нээлттэй хангаж ажиллалаа.

"Монголын хөрөнгийн бирж" нь 33 жилийнхээ босгон дээр МУ-ын хөрөнгийн зах зээлийн салбарын оны шилдгийг шалгаруулдаг "Grand bull awards-2023"-аас ОНЦЛОХ IPO номинацид шалгарсан зэрэг чамлахааргүй амжилттай ажиллаж байна.

2022 2023

ЗАХ ЗЭЭЛИЙН  
ҮНЭЛГЭЭ

₮6.89  
их наяд

₮11.6  
их наяд

ТОП-20 ИНДЕКС

37,565.55  
нэгж

41,437.42  
нэгж

БҮРТГЭЛТЭЙ  
КОМПАНИЙН ТОО

183

173


ӨДРИЙН ДУНДАЖ  
АРИЛЖАА

₮2.4  
тэрбум

₮33.3  
тэрбум

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТҮҮХЭН ТОВЧООН







# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ГАЗРУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

**Захиргаа, санхүүгийн газар** нь компанийн дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба, Хуулийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Үйл ажиллагааны газар** нь арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах үндсэн чиг үүрэгтэйгээр Арилжааны алба, Мэдээлэл технологийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Хяналт, зохицуулалтын газар** нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

**Бизнес хөгжлийн газар** нь Маркетинг, олон нийттэй харилцах алба, Зах зээлийн хөгжлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж, салбарын төлөв байдал, олон улсын чиг хандлагад тулгуурлан биржийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг ханган, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж ажилладаг. Түүнчлэн биржийн өдөр тутмын үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, зах зээлийг идэвхжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зах зээлийн мэдээ, мэдээллийн бодит эх сурвалж болж ажилладаг.

**Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, бүртгэлийн газар** нь уул уурхайн бүтээгдэхүүнийг бүртгэх, арилжих, зах зээлд оролцогчдыг бүртгэн итгэмжлэх, арилжааны зуучлагчийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийг уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны гишүүнээр элсүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, журам болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

## УДИРДЛАГЫН БАГ



### Х.АЛТАЙ

#### Гүйцэтгэх захирал

- 2016 оноос эхлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

#### Боловсрол:

- 2018-2020 Бизнесийн удирдлага, Магистр СЭЗДС, Монгол Улс
- 1999-2004 Эрх зүйч, Бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургууль Монгол Улс

#### Ажлын туршлага:

- 2015-2016 “БИ БИ энерги” ХХК-ийн Монгол Улс дахь төлөөлөгч
- 2010-2012 МУ-ын ЗГ, Ерөнхий сайдын Ажлын алба, Ерөнхий сайдын зөвлөх
- 2011-2014 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2010-2011 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал
- 2004-2007 “Боро гоулд ХХК”-ийн Засгийн газартай харилцах алба
- 2003-2007 МУ-ын ЗГ, Ерөнхий сайдын Ажлын алба, Ерөнхий сайдын шадар туслах



### Т.ХАШ-ЭРДЭНЭ

#### Бизнес хөгжлийн газрын захирал

- 2022 оноос эхлэн “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал

#### Боловсрол:

- 2001-2005 Олон улсын ЭЗ-ийн харилцаа, Бакалавр, РУДН ОХУ
- 2019-2023 Эрх зүйч, Бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургууль Монгол Улс

#### Ажлын туршлага:

- 2021-2022 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дэд захирал
- 2021 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх
- 2018-2021 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын албаны дарга
- 2017-2018 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын Олон нийттэй харилцах бодлого хариуцсан Орон тооны бус зөвлөх
- 2012-2017 “Монгол Медиа Корпораци” ХХК-ийн Газрын захирал



### А.МӨНХБАЯСГАЛАН

#### Хяналт, зохицуулалтын газрын захирал

- 2017 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал

#### Боловсрол:

- 1994-1999 Бизнесийн удирдлага Бакалавр, Парисын 9 дүгээр их сургууль Франц улс
- 1999-2000 Төрийн удирдлага, Магистр Парисын 9 дүгээр их сургууль Франц улс

#### Ажлын туршлага:

- 2015-2017 Сангийн яамны газрын дарга
- 2006-2015 ХХБ ХХК-ийн Газрын захирал
- 2005-2006 Үйлдвэрлэл, худалдааны яамны мэргэжилтэн
- 2004-2005 СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн Бизнесийн удирдлагын багш



### Х. ЭРДЭНЭБҮРЭН

#### Захиргаа, санхүүгийн газрын захирал

- 2023 оны 07 дугаар сараас эхлэн “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Захиргаа, санхүүгийн газрын захирал

#### Боловсрол:

- 2014-2016 Магистр, Бизнесийн удирдлага, ЭЗҮДС, Монгол Улс
- 1993-1997 Бакалавр, Эдийн засагч, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улс

#### Ажлын туршлага:

- 2020-2023 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Санхүүгийн албаны ахлах мэргэжилтэн
- 2015-2017 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Санхүүгийн албаны ахлах мэргэжилтэн
- 2005-2015 Өнгө Ингүүмэл ББСБ-ын Гүйцэтгэх захирал
- 1999-2005 Тээвэр хөгжлийн банкны Салбарын захирал
- 1998-1999 Улаанбаатар хотын банкны Нягтлан бодогч

### И.ЖАВХЛАН

#### Үйл ажиллагааны газрын захирал

- 2020 оноос эхлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

#### Боловсрол:

- 2016 Санхүүгийн удирдлага, магистр Мельбурн Их сургууль, Австрали улс
- 2005-2009 Олон улсын эдийн засгийн харилцаа Бакалавр, МУИС-ОУХС, Монгол Улс

#### Ажлын туршлага:

- 2017-2020 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Зах зээл хөгжийн албаны Ахлах мэргэжилтэн
- 2011-2015 “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Бүртгэлийн албаны Ахлах мэргэжилтэн



## ХҮНИЙ НӨӨЦ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав.

Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2023 оны эцэст нийт 70 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.



70

Нийт ажилтан



22

Нийт эрэгтэй ажилтан



48

Нийт эмэгтэй ажилтан



38

Үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн




32

Дэмжих үйл ажиллагааны мэргэжилтнүүд



36

Дундаж нас



6 жил

Ажилласан дундаж хугацаа



16

Удаагийн сургалт



67

Дээд боловсрол

19 Магистр

2 Тусгай дунд

48 Бакалавр

1 Бүрэн дунд



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН  
НЯГТЛАН БОДОГЧДЫН  
ИНСТИТУТ

3

Мэргэшсэн  
нягтлан бодогч



CFA Institute

2

Олон улсын  
итгэмжлэгдсэн  
санхүүгийн шинжээч  
цол горилогч

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

“Монголын хөрөнгийн бирж” ХК  
“Mongolian stock exchange” JSC

Хэлбэр:

Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:

2071096

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын хөрөнгийн бирж

Хувьцааны бүртгэлийн ангилал:

I

Симбол:

MSE

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:

350,463,539

ISIN дугаар:

MN00MSE05100

Үйл ажиллагааны чиглэл:

- 66110 - Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага
- 66190 - Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн эрх барих дээд удирдлага нь хувьцаа эзэмшигчид байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023.04.28-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд А.Амарын гудамж, 15 хаягт байрлах Бэст вестерн премьер Туушин зочид буудлын Соёмбо танхимд цахим болон танхимаар 72.81%-ийн ирцтэй хуралдаж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлав.

- Ногдол ашиг хуваарилах эсэх талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцаж батлав.

- Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлав.

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоов.

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлав.

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлав.

- Тус хурлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ТУЗ-ийн хоёр гишүүний чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг харгалзан, тэдгээр гишүүдийн оронд жижиг хувьцаа эзэмшигчдээс хоёр гишүүнийг томилох үүргийг ТУЗ-д өглөө.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулж дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж батлав.

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэж батлав.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

2023 он

7,453

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдээр Б.Батбаяр, Б.Туяарах, Ц.Мөнхзул, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр С.Баянцогт, Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, хараат бус гишүүдээр Р.Мөнхтөр, Н.Отгончимэг, М.Банзрагч, Н.Улаанхүү нарыг 3 жилийн хугацаатай сонгов.

### ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 51.4 сая ширхэг үнэт цаас нийт 7.6 тэрбум төгрөгөөр арилжигдлаа. Компанийн зах зээлийн үнэлгээ 2023 оны эцэст 40 тэрбум 993 сая төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээгээр 27-р байрт эрэмбэлэгдлээ.

Хувьцааны ханш:

- Хаалт 116.97
- Дундаж 135.4 төг,
- Дээд 201.12 төг (2023.01.13-ны өдөр),
- Доод 104 төг (2023.09.11-ний өдөр) байв.

Хувьцааны ханшийн график



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2023-2027 оны стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрэм болон "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-д тодорхой заасан байдаг.

## ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

## Аудитын хорооны бүрэлдэхүүн

Н. Улаанхүү	Хорооны дарга
Р. Мөнхтөр	Гишүүн
Ж. Цогтбаяр	Гишүүн

## Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Р. Мөнхтөр	Хорооны дарга
Н. Улаанхүү	Гишүүн
С. Баянцогт	Гишүүн

## Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Н. Отгончимэг	Хорооны дарга
М. Банзрагч	Гишүүн
Т. Ганбаатар	Гишүүн

## Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

М. Банзрагч	Хорооны дарга
Н. Отгончимэг	Гишүүн
Ж. Бямбасүрэн	Гишүүн

## ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг хийдэг.

## ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон

шалгаруулалтаар сонгон 3 жилийн хугацаагаар томилж, Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2023 оны 6-р сарын 30-ны өдрөөс Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид нээлттэй сонгон шалгаруулалтаар дараах гишүүдийг сонгож 3-н жилийн хугацаатай томилсон.

## ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог. 2023 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт ороогүй байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЦ, УР ЧАДВАР

	НЭР	АЛБАН ТУШААЛ	Томилогдсон огноо
1	Д.ТОГТОХБАЯР ТУЗ-ийн дарга	МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	2023.06.30
2	С.БАЯНЦОГТ Ердийн гишүүн	"Алтайн зам" ХК-ийн Санхүүгийн хэлтсийн захирал	2023.06.30
3	Ж.БЯМБАСҮРЭН Ердийн гишүүн	ЗГХЭГ-ын Санхүү, эдийн засгийн газрын дарга	2023.06.30
4	Т.ГАНБААТАР Ердийн гишүүн	УУХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга	2023.06.30
5	Ж.ЦОГТБАЯР Ердийн гишүүн	Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга	2023.06.30
6	М.БАНЗРАГЧ Хараат бус гишүүн	ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Сургалт, чанарын албаны дарга	2023.06.30
7	Р.МӨНХТӨР Хараат бус гишүүн	"Айкор партнерс" ХХК-ийн Дэд захирал	2023.06.30
8	Н.ОТГОНЧИМЭГ Хараат бус гишүүн	"Сүлд-Аудит" ХХК-ийн Аудитор	2023.06.30
9	Н.УЛААНХҮҮ Хараат бус гишүүн	Ландбридж" ХХК-ийн Санхүү, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2023.06.30



## ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлага

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах гишүүдийн хамтын ур чадварт байж болох ур чадварын дутуу орон зайг илрүүлэх, гишүүдийн ур чадвар, ажлын туршлагыг үнэлэх зорилгоор өмнөх хүснэгтээр харуулсан матрицыг хэрэглэдэг. Гишүүдийн салбарын мэдлэг туршлага, мэргэжлийн ур чадвар болон хүйсийн тэнцвэртэй харьцааг хадгалах нь МХБ-д тулгарч байгаа асуудал, сорилтуудыг оновчтойгоор шийдвэрлэх, гүйцэтгэх захирал болоод удирдлагын багийн бусад гишүүд үйл ажиллагааны стратеги төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлж байгаад бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чухал үүрэгтэй.

ТУЗ өөрийн бүтэц, бүрэлдэхүүнийг зохих түвшинд байна гэж үзсэн бөгөөд компанийн сайн засаглалын зарчмын дагуу ур чадвар, бүтэц, бүрэлдэхүүний тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж ирсэн.

## ТУЗ-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Компанийн тухай хууль”-ийн 75.9 дэх зүйлд заасны дагуу МХБ-ийн ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2023 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн бүх гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2023 онд ТУЗ нийт 27 удаа хуралдсан. ТУЗ-ийн хурлаар нийт 60 гаруй асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 54 тогтоол гаргаж, 9 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн 20 удаагийн хурал Улаанбаатар хотод МХБ-ийн хурлын танхимд, 3 удаа эчнээ хэлбэрээр зохион байгуулагдсан ба 4 удаагийн хурал цахим хэлбэрээр явагдсан байна.

Тайлант онд Төлөөлөн удирдлах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороогоор 9 асуудал хэлэлцэж, 9 дүгнэлт, Нэр дэвшүүлэх хороогоор 5 асуудал хэлэлцэж 5 дүгнэлт, Цалин урамшуулын хороогоор 4 асуудал хэлэлцэж 4 дүгнэлтийг тус тус гаргаж ажилласан байна.

## Цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч ердийн гишүүдэд цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын дагуу тогтоодог ба гишүүдийн

цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг. МХБ-ийн хараат бус гишүүд болон хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын бүтэц ердийн гишүүдийн цалин урамшууллын бүтэцтэй адил байна. ТУЗ-ийн гишүүнд зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр, нөхөн олговор олгодоггүй. 2023 онд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин хөлсийг дараах хүснэгтээр харуулав.

### ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

1 сарын цалин хөлс, ₮

1	ТУЗ-ийн дарга	1,100,000₮
2	Ердийн гишүүд	1,080,000₮
3	Хараат бус гишүүд	1,080,000₮
4	ТУЗ-ын нарийн бичгийн дарга	861,307.92₮



### Ашиг сонирхлын зөрчил

Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу гишүүд эзэмшиж байгаа үнэт цаасны талаарх мэдээллийг ил тод танилцуулах үүрэгтэй.

Түүнчлэн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар гишүүн бүр Авлигатай тэмцэх газар ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг өгдөг.

Мөн ТУЗ-ийн гишүүн хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд тухайн асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй.

### Хараат бус аудит

МХБ-ийн ТУЗ-ийн аудитын хорооноос шалгаруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн сонгосон хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага болох “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-тай “Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийсэн. Тус аудитын байгууллага МХБ-ийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг шалган санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнг үнэн зөв илэрхийлсэн, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон компанийн тухай хууль тогтоомжийг дагаж мөрдсөн эсэх талаар дүгнэлт гаргах үүрэгтэй.

Аудитын баг нь МХБ-ээс ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд мөн аудитын үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдсон нөхцөл байдлын хувьд хараат бус байсан тухайгаа илэрхийлсэн.

Хараат бус аудитын дүгнэлтийг 43-р хуудаснаас үзнэ үү.

### Гишүүдийн бие даасан байдал

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд хараат бус гишүүн олон байх нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт эерэг нөлөөтэй. МХБ-ийн ТУЗ нь “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”-ийн 7.1 дэх заалтын дагуу хараат бус 4 гишүүнтэй байна. Нэр дэвшүүлэх хороо шинэ гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг “Авлигатай тэмцэх газар”-т /АТГ/ хүргүүлэн гишүүний бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллахад, мөн бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

### Мэдээллийн ил тод байдал

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь үнэт цаасны 1 дүгээр ангилалд бүртгэлтэй компани тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн нийтэд толилуулах үүрэгтэй.

“Компанийн тухай хууль”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу хувьцаа эзэмшигч, зах зээлд оролцогч байгууллагууд, иргэдийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны тойм танилцуулга, сар тутмын гол үйл явдлуудын эмхэтгэл зэрэг үйл ажиллагааны мэдээллээс гадна хөрөнгийн зах зээлийн өдөр тутмын үйл явдлын мэдээ, мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан монгол, англи хэлээр, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг монгол, англи, хятад хэлээр тогтмол хүргэдэг бөгөөд олон нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг тухайлчлан зарим этгээдэд мэдээлдэггүй.

## ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### Хяналтын зөвлөлийн үндсэн чиг үүрэг

"Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн дүрэм болон Хяналтын зөвлөлийн ажиллах журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс компанийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэгтэй. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хуулийн дагуу хамгаалах чиглэлээр санал гаргаж ТУЗ-д хүргүүлэх,
- Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн гомдлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж гаргаж ТУЗ-д хүргүүлэх,
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвлөмж гаргаж компанийн гүйцэтгэх захиралд хүргүүлэх

### Хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06-р сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрээр томилогдсон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

### Цалин урамшуулал

Хяналтын зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг. Хяналтын зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог ба гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тухайн сард хуралдсан эсэхээс хамааруулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосон. Хяналтын зөвлөлийн гишүүдэд олгосон цалин хөлсийг дараах хүснэгтээр харуулав.

1 сарын цалин хөлс, ₮


№	Хяналтын зөвлөлийн гишүүн	Цалин хөлс, ₮
1.	Хяналтын зөвлөлийн гишүүн	1,100,000₮

### Хяналтын зөвлөлийн гишүүд

№	НЭР	АЛБАН ТУШААЛ	ТОМИЛОГДСОН ОГНОО
1.	Д.Батбаяр	"Ди Си Эф ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	2023.06.30
2.	Б.Туяарах	Дэлхийн банкны зөвлөх	2023.06.30
3.	Ц.Мөнхзул	Хуульч, өмгөөлөгч	2023.06.30

2023 онд хяналтын зөвлөлийн нийт гишүүдийн 66.6% нь эмэгтэй гишүүд байв. Гишүүдийн МХБ-ийн хяналтын зөвлөлийн гишүүнээр ажилласан хугацаа болон насны бүтцийг дараах графикаар үзүүлээ.

#### Гишүүдийн нас



#### Гишүүнээр ажилласан хугацаа



### Хяналтын зөвлөлийн хурал

- Хяналтын зөвлөл 2023 онд 11 удаа хуралдсан.

### Хурлаас гарсан шийдвэр

- Хяналтын зөвлөлд 2023 онд 3 хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нэг хүсэлт тус тус гаргасан байна.

Хяналтын зөвлөл нь хувьцаа эзэмшигчээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч хувьцаа эзэмшигчийн эрх, ашиг сонирхолд нийцэх, хамгаалах талаар тухай бүр дүгнэлт, санал, зөвлөмж гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлж ажилласан. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг хуулийн дагуу хангах, хамгаалах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажилласан бөгөөд компанийн Захиргаа, санхүүгийн газрын захиралтай 2 удаа уулзалт зохион байгуулж дэнчингийн мөнгөн хөрөнгө, олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, холбогдох бусад санхүүгийн мэдээлэлд тайлбар, тодруулга авч компанийн 2022-2023 оны санхүүгийн тайланг дүгнэн хувьцаа эзэмшигчийн тэргүүн зорилго болох хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх,

ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах зэрэг саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн.

Түүнчлэн Хяналтын зөвлөл жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлтэй 2 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн төлөөлөлтэй 1 удаа, компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчтэй 1 удаа тус тус уулзалт зохион байгуулж компанийн засаглал үйл ажиллагааны ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх байдлаар санал солилцсон.

### Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт:

Хяналтын зөвлөлөөс 2023 оны ТУЗ-д хүргүүлсэн санал зөвлөмжийн дагуу ТУЗ-өөс компанийн татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн төлөвлөгөөг нарийвчлан төлөвлөх, мөнгөн хөрөнгийн удирдлагын журам баталж хэрэгжүүлэн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулж гүйцэтгэх захирал, газрын захирлуудын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах, компанийн цэвэр ашгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний ногдол ашгийг хуваарилах зэрэг шийдвэрийг гаргаж ажилласан байна.



### Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. ТУЗ-ийн 2017 оны 10 сарын 12-ны өдөр байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-г сунгахаар шийдвэрлэсний дагуу тайлант хугацаанд гүйцэтгэх захирлаар Х.Алтай ажилласан. 2023 онд МХБ-ийн 2023 оны бизнес төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, холбогдох дүрэм журмыг боловсруулж ажилласан.


# ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

# 2023



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

## ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ ТУРШИЛТЫН АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хүрээнд нүүрсний арилжаанд оролцогч талууд болох нүүрс худалдах болон худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийг оролцуулсан туршилтын дуудлага арилжааг 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Энэхүү туршилтын дуудлага арилжаагаар, худалдах талаас 2 багц буюу нийт 12,800 тонн нүүрсийг худалдах санал ирүүлсэн бөгөөд 1 удаагийн хэлцлээр 2 багц нүүрсийг амжилттай арилжиж, дуудлага арилжаагаар дуудах үнэ 12.2 хувиар өссөн юм.

## БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ЗӨВЛӨХ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛОО

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны зөвлөх ноён Сун Сюежун, Монгол Улс дахь БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын ЗУН-ХУА нийгэмлэгийн дэд тэргүүн ноён Чай Фанпин болон Элчин сайдын яамны холбогдох мэргэжилтнүүд Монголын хөрөнгийн биржид зочилсон.

Уулзалтын үеэр Гүйцэтгэх захирал Х.Алтай Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын чиг хандлагын талаар танилцуулж, Монголын хөрөнгийн зах зээлд БНХАУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжуудын талаар санал солилцов. Түүнчлэн, экспортын нүүрсийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй арилжихаар болсонтой холбогдуулан нүүрс худалдан авагч БНХАУ-ын компаниудад нүүрсний арилжаанд оролцох боломж, ач холбогдлын талаар таниулан сурталчлах чиглэлээр хамтран ажиллах боломжуудын талаар хэлэлцсэн юм.



## ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКНЫ УДИРДЛАГУУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛОО

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Дэд Ерөнхийлөгч бөгөөд Эрсдэл хариуцсан захирал хатагтай Аннемери Стратхоф, тус банкны Төв Азийг хариуцсан захирал хатагтай Сюзанна Харгитай болон тус банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч ноён Ханнес Такач нар Монголын хөрөнгийн биржид зочиллоо.

Уулзалтын үеэр МХБ-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай хөрөнгийн зах зээлийн сүүлийн үеийн нөхцөл байдал, системийн нөлөө бүхий банкуудын үнэт цаас гаргалт, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа болон төрийн өмчит компаниудын нээлттэй компани болох үйл явцын талаар танилцуулж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх, тогтвортой өсөлтийг хангахад ЕСБХБ-ны оролцоо чухлыг онцолж, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлуудын талаар хэлэлцсэн юм.



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.АЛТАЙ БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН АЛБАНЫ ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай 2023 оны 04 дүгээр сарын 24-нд Бүгд Найрамдах Польш Улсын Эдийн засаг, Хөгжил, Технологийн яамны Худалдаа, Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Бартломей Левандовски, Польшийн Хөрөнгө Оруулалт, Худалдааны агентлагийн дэд ерөнхийлөгч Здислав Сокаль нарыг хүлээн авч уулзав.

Уулзалтаар хоёр орны эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлагын талаар, тэр дундаа хоёр орны хөрөнгийн биржүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, өргөжүүлэх боломж бололцоог бий болгох чиглэлээр харилцан санал солилцсон.

Варшавын хөрөнгийн бирж нь төр, хувийн өмч хосолсон групп компани бөгөөд 700 гаруй бүртгэлтэй компанитай, Төв болон Зүүн Европын бүс нутагтаа хамгийн өндөр үнэлгээтэй хөрөнгийн бирж юм.

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК БУДАПЕШТЫН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ХК болон Будапештын хөрөнгийн биржийн удирдлагууд 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахим уулзалт хийж, хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэлээ.

Энэхүү цахим уулзалтад “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Бизнес хөгжийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан, Будапештын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Ричард Вэй /Richard Vegh/, Гүйцэтгэх захирлын орлогч Истван Мате-Тот /Istvan Mate-Toth/, Унгарын Төв банкны Олон улсын шинжээч Лүи Пинтер /LUYI Pinter/ нар оролцож, хоёр байгууллагын удирдлагууд санамж бичигт гарын үсэг зурсан.

Санамж бичгийн хүрээнд талууд хоёр улсын зах зээлийн мэдээлэл солилцох, хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, хурал, семинар зохион байгуулах, хамтарсан бүтээгдэхүүн гаргаж хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах юм.



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2023 ОНД ХИЙСЭН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ **COMEX**  
АРИЛЖААНЫ СИСТЕМИЙГ ШИНЭЭР  
ХӨГЖҮҮЛЭВ



ЗГҮЦ-НЫ АРИЛЖААНЫ **BOND.MSE.MN**  
ПЛАТФОРМЫГ ШИНЭЭР ХӨГЖҮҮЛЭВ



АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ **IPO**  
СИСТЕМИЙН НЭМЭЛТ САЙЖРУУЛАЛТ



ДЭД БҮТЭЦ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭВ

## СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ БАНКУУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАМЖУУЛАН IPO ГАРГАЛАА




УИХ-аас баталсан Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн /2021.01.29/ дагуу системийн нөлөө бүхий банкуудын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн хүрээнд Төрийн банк, Голомт банкууд 2022 онд, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк 2023 онд тус тус Монголын хөрөнгийн биржээр дамжуулан IPO гаргаж, олон нийтийн хувьцаат компани болсон юм.

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК ШАНХАЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун Эрдэнийн БНХАУ-д хийсэн албан айлчлалын хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай “Шанхайн хөрөнгийн бирж”-ийн Ерөнхийлөгч Цаи Жианчун /Cai Jianchun/ болон албаны бусад хүмүүстэй албан уулзалт хийж, хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

Санамж бичгийн хүрээнд талууд хөрөнгийн зах зээлийн мэдээлэл солилцох, хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг сангийн хөгжүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, хоёр орны зах зээлийн орчин нөхцлийг харилцан сурталчлах, дэд бүтцийг өргөжүүлэх, хамтарсан бүтээгдэхүүн гаргаж хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон юм.



## “ХАМТЫН БИРЖЭЭР АРИЛЖААЛАГДДАГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ” БАТЛАМЖЛАГДАВ.

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ыг шинээр боловсруулж ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 48 тоот тогтоолоор баталсан. Тус журмыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04 тоот тушаалаар батламжилж мөн өдрөөс дагаж мөрдөж эхэллээ.



## “МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН 2023”-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛОО

“Welcome to Mongolia” уриан дор зохион байгуулагдсан “Монголын эдийн засгийн чуулган 2023”-д уригдсан олон улсын хөрөнгө оруулагч, гадаадын Хөрөнгө оруулалтын банк, сангуудын төлөөлөл 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Монголын хөрөнгийн биржид зочиллоо.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай хүндэт зочдод Монгол улсын хөрөнгийн зах зээлийн тойм танилцуулгыг хийж, “Networking event”-ээр олон улсын хөрөнгө оруулагчид, Монголын хөрөнгийн биржийн газрын захирлууд болон брокер, дилерийн компаниудын төлөөлөл харилцан туршлага солилцсон юм.

Үйл ажиллагаанд Deutsche Bank, UBS, JPMorgan, Goldman Sachs, Sumitomo Mitsui, Barclays, Bank of China, Morgan Stanley, US EXIM, Citi, BNP Paribas Exane, HSBC Australia Bank, Standard Chartered, ING, Lazard Asset Management, Export Finance Australia, MIGA, Clifford Capital, Bank of America, RBC, Barrenjoey Capital Partners, Natix is HK, GIC, Ubique Asset Management, EBRD, IFC, KFW, Canadian Imperial Bank of Commerce зэрэг олон улсын нөлөө бүхий 40 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон билээ.



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д олгосон.

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй, ил тод, шударга зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтох боломж бүрдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор УИХ-аас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан 11 харилцааг зохицуулсан нэр бүхий таван журмыг боловсруулсан бол тус хуралдаанаар эдгээр журмыг мөрдүүлэх зөвшөөрлийг олгож, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйлчилгээний хураамжийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас хүргүүлсэн санал, судалгааг харгалзан тогтоогоод байна.





## БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА НЭЭЛТТЭЙ ТАНИЛЦУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үүргийн хэрэгжилт, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХБ-ийн бүртгэлтэй компаниудын хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй илтгэл хэлбэрээр танилцуулах ажлыг 2023 оны 8 дугаар сарын 7-23-ны өдрүүдэд 8 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 1-р ангилалд “Монголын Хөрөнгийн Бирж” ХК, “Би ди сек” ХК, “Ард санхүүгийн нэгдэл” ХК, “Ард кредит ББСБ” ХК, “Газар Шим Үйлдвэр” ХК, “Ард Даатгал” ХК, “Хаан банк” ХК, “Инвекор ББСБ” ХК, “Монос хүнс” ХК, “Богд Банк” ХК, “ЛэндМН ББСБ” ХК, “АПУ” ХК, “Мандал Даатгал” ХК, “Мик холдинг” ХК, “Төрийн Банк” ХК, “Сүү” ХК, “Талх чихэр” ХК, “Худалдаа Хөгжлийн банк” ХК, “Түмэн шувуу” ХК, “Голомт Банк” ХК, 2-р ангилалд бүртгэлтэй “Айтүүлс” ХК нийт 21 компаниуд оролцож, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулсан юм.



## ТӨМРИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭВ



“Монголын хөрөнгийн бирж” ХК нь уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон өргөжсөнөөс хойш 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр төмрийн баяжмалын анхны арилжааг эхлүүлсэн.

Төмрийн баяжмалын анхны арилжааг эхлүүлэх ёслолын ажиллагаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Дугаржав, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Зэс, металл группийн менежер Ц.Төгсбуян, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Эдийн засаг, худалдааны бодлогын газрын дарга Н.Тэгшжаргал болон албаны бусад хүмүүс оролцож цан цохин анхны арилжааг нээсэн юм.

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК АРИЛЖААНЫ СИСТЕМ ИЙН ДЭД БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЭВ



“Монголын хөрөнгийн бирж” ХК нь арилжааны систем, дэд бүтцийн шинэчлэлийг тогтмол хийх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба тус төлөвлөгөөний хүрээнд Миллениум арилжааны системийн дэд бүтцийн шинэчлэлийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Уг ажлын хүрээнд шинээр суурилуулсан арилжааны үндсэн системд 2023 оны 09 дүгээр

сарын 04-нөөс 08-ны өдрүүдэд хэрэглэгчийн хүлээн зөвшөөрөх шатны туршилт (User Acceptance test), 2023 оны 09 дүгээр сарын 09 болон 16-ны өдрүүдэд хөрөнгийн зах зээлийн нийт оролцогч талуудыг хамарсан хийсвэр арилжааны туршилт (Mock Test)-ыг тус тус зохион байгуулж, 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн уг системийн шинэчлэлийг арилжаанд амжилттай нэвтрүүлсэн юм.

## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Хамтын ажиллагааны санамж бичигт “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Монголын Хуульчдын холбооны ерөнхийлөгч П.Одгэрэл нар гарын үсэг зурсан.

Санамж бичгийн хүрээнд талууд олон улсын хурал зөвлөгөөн форумд хамтран оролцох, нөлөөллийн ажлыг хамтран зохион байгуулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэ хуулийн төсөл, дүрэм, журам боловсруулахад харилцан мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана. Мөн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, Монголын Хуульчдын холбооны Сургалтын хороогоор дамжуулан хөрөнгийн зах зээл, уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, түүнтэй холбоотой татварын орчны чиглэлээр хуульчдад болон хөрөнгийн биржийн оролцогчдод сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, магадлан итгэмжлүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон юм.



## АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ҮНЭД ҮНДЭСЛЭН ТООЦОХООР БОЛЛОО

Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 345 дугаар тогтоолоор “Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай” Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулж, 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжигдсан уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ийг тооцохдоо Монголын хөрөнгийн биржийн арилжааны үнийн мэдээллийг үндэслэл болгохоор боллоо.

АМНАТ-ийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.3 болон 47.17 дахь заалтуудын дагуу тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5-10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр тооцдог бөгөөд борлуулалтын үнэлгээг тооцохдоо тухайн бүтээгдэхүүн Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан эсэхээс үл хамааран [www.sxcoal.com](http://www.sxcoal.com), [www.umetal.com](http://www.umetal.com), [www.indmin.com](http://www.indmin.com) зэрэг олон улсын эх сурвалжид нийтлэгдсэн үнийн мэдээллийг ашиглах зохицуулалттай байсан.

Ийнхүү тус шийдвэрийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч компаниуд Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан нүүрс, төмөр, хайлуур жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний АМНАТ-ийг биржийн арилжааны үнэ ханшийн мэдээлэлд тулгуурлан төлөх боломжтой болсон нь бүтээгдэхүүнээр биржээр дамжуулан ил тод, нээлттэйгээр худалдах компаниудын тоог нэмэгдүүлэх, уул уурхайн салбарын ил тод байдлыг дээшлүүлэхэд эерэг үр нөлөө үзүүлэх юм.

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ САР БҮР ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ

“Монголын Хөрөнгийн бирж” ХК-иас зохион байгуулдаг “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт” ковид-19 цар тахлын нөлөөгөөр түр хугацаанд завсарлаад байсан бол 2023 оны 10 дугаар сараас эхлэн Монголын хөрөнгийн биржийн сургалтын танхимд сар тутам тогтмол зохион байгуулагдаж байна.

Сургалтын хөтөлбөр:

- Хөрөнгийн зах зээлийн үүсэл, хөгжил
- Хувь хүний санхүү
- Хувьцаа, бондын ялгаа
- Брокер, дилерийн үндсэн үйл ажиллагаа
- Хөрөнгө оруулалтын төрөл, зорилго
- Финтек ба крипто валют
- Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын тухай
- Хөрөнгийн зах зээлийн ач холбогдол
- Багц бүрдүүлэлтийн талаар
- МХБ-ийн үнэт цаасны арилжаа, түүнд оролцох үйл явц
- Арилжааны систем ашиглах практик сургалт
- Бататгах давтлага



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АНХАН ШАТНЫ МЭДЛЭГЭЭ БАЯЖУУЛСАН СУРАЛЦАГЧИД СЕРТИФИКАТАА ГАРДАН АВЛАА

## МОНГОЛ УЛСЫН АНХНЫ НОГООН БОНД БҮРТГЭГДЭВ.



“ХААН банк” ХК-ийн нийтэд санал болгосон ногоон бонд нь төгрөг, ам.долларын хосолсон хэлбэрээр гарсан бөгөөд олон улсын “Sustainable Fitch” байгууллагаар ногоон бондын зарчимтай нийцсэн талаарх дүгнэлт гаргуулснаар онцлох шинэ бүтээгдэхүүн болсон юм.

ХААН Банк дотооддоо ногоон бонд гаргаснаар Монголын хөрөнгийн зах зээлд ногоон бүтээгдэхүүн нэмэгдэж, хөрөнгийн зах зээлийг тэлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨРЛӨГИЙГ ШАНХАЙ ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ХК 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр БНХАУ-ын Шанхайн хөрөнгийн биржтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийсэн албан айлчлалын үеэр талууд энэхүү санамж бичгийг үзэглэсэн бөгөөд хоёр улсын зах зээлийг харилцан сурталчлах, зах зээлийг холбосон бүтээгдэхүүн нэвтрүүлэх, туршлага мэдээлэл солилцох зорилгыг агуулсан юм.

“Монголын хөрөнгийн бирж” ХК, Шанхайн хөрөнгийн бирж хамтран 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Шанхайд төвтэй хөрөнгө оруулалтын сан, зах зээлийн оролцогчдыг хамруулсан “MONGOLIAN CAPITAL MARKETS DAY 2023” өдөрлөгийг тус хотод амжилттай зохион байгуулсан.



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК “GRAND BULL AWARDS 2023”-ЫН “ОНЦЛОХ IPO”-НОМИНАЦИД ШАЛГАРЛАА



### “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК НЬ МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНД ХАМТРАГЧ ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК нь 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоонд (МҮЦАЭХ) хамтрагч гишүүн байгууллагаар элслээ. Гишүүн байгууллага болсноор үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжиж, зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, зах зээлийн оролцогч байгууллага, хөрөнгө оруулагчдад ил тод, нээлттэйгээр зах зээлийг хөгжүүлэх, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлсэн үйл явдал боллоо.

Монголын хөрөнгийн зах зээлийн оны шилдгүүдийг тодруулан өргөмжилдөг “Grand Bull Awards 2023” ёслолын арга хэмжээ 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдаж, “Монголын хөрөнгийн бирж” ХК “Онцлох IPO” номинацид шалгарсан юм.

Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 2022 оны 12 сарын 26-нд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд амжилттай санал болгон, хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн.

Түүнчлэн энэ онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжин банкны реформ амжилттай хэрэгжиж, системийн таван банк хувьцаат компани боллоо. Мөн бирж нь үнэт цаас арилжихаас гадна Монгол Улсын экспортын үндсэн бүтээгдэхүүн уул уурхайн түүхий эдийн арилжааг амжилттай нэвтрүүлээд байна.

### ХУВЬЦАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖААНЫ ШИМТГЭЛИЙГ БУУРУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар Монголын хөрөнгийн биржийн “Арилжааны журам”-д шимтгэлийн хувь хэмжээг бууруулах тухай нэмэлт өөрчлөлт оруулан Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулсан.

Ингэснээр 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржээр хийгдэх хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны үнийн дүнгээс үл хамааран 0.3 хувиар шимтгэл тооцож эхлэхээр болсон.

Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд тохируулан авч буй энэхүү арга хэмжээ нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийх зардлыг бууруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

### “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, иргэдийг хөрөнгийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангах, үнэт цаас гаргагчдад зөвлөмж өгөх зорилгоор “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Нээлттэй өдөрлөгт Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ТӨХК, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, 8 үнэт цаасны компаниуд оролцож үнэт цаасны зах зээл, арилжааны практикийн талаар сургалт явуулахын зэрэгцээ үнэт цаастай холбоотой иргэдийн санал хүсэлтэд хариулт өгч, иргэдийг хөрөнгийн зах зээлийн мэдээ мэдээллээр хангаж ажилласан юм.



## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

	Үнэт цаасны төрөл	Олон нийтэд санал болгосон дүн /тэрбум/	Захиалгын дүн	Захиалгын хувь	Хөрөнгө оруулагчдын тоо
“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК	Хувьцаа	₮ 10.49	₮ 11.47	109%	2,879
“ХААН БАНК” ХК	Хувьцаа	₮ 183.38	₮ 336.38	183%	29,345
“ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК” ХК	Хувьцаа	₮ 83.49	₮ 105.52	126%	2,482
“ХАС БАНК” ХК	Хувьцаа	₮ 35.68	₮ 41.82	117%	10,708
“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХК	Хувьцаа	₮ 10.99	₮ 11.32	103%	1,269
“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК	Хувьцаа	₮ 8.32	₮ 8.35	100%	1,155
“СЭНДЛИ ББСБ” ХК	БОНД	₮ 8.50	₮ 8.50	100%	207
“ИНВЕСКОР ББСБ” ХК	БОНД /ТРАНЧ 3/	₮ 10.0	₮ 10.0	100%	81
“БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ” ХХК	БОНД	₮ 8.0	₮ 8.0	100%	127
“ИНВЕСКОР ББСБ” ХК	БОНД /ТРАНЧ 4/	₮ 10.0	₮ 10.0	100%	81
“СИМПЛ АССЕТ ТЗК” ХХК	БОНД	₮ 20.0	₮ 20.0	100%	64
“ИНВЕСКОР ББСБ” ХК	БОНД /ТРАНЧ 5/	₮ 10.0	₮ 10.0	100%	75
“ЛЭНДМН ББСБ” ХК	БОНД	₮ 9.0	₮ 9.0	100%	89
“СИМПЛ АССЕТ ТЗК” ХХК	БОНД /ТРАНЧ 2/	₮ 15.0	₮ 15.0	100%	158
“ХААН БАНК” ХК	БОНД /НОГООН БОНД/	₮ 17.0	₮ 17.0	100%	41
“БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС” ТЗК	ХБУЦ	₮ 9.0	₮ 9.0	100%	58
“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ПЛАС” ТЗК	ХБУЦ	₮ 20.0	₮ 20.0	100%	132
“ОМНИ АССЕТ” ТЗК	ХБУЦ	₮ 6.0	₮ 6.0	100%	66



ХААН БАНК



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

₮11.62

их наяд

+168.7%

+4.73

их наяд

### ТОП-20 ИНДЕКС

41,437.42

нэгж

+10.31%

+3,871.8

нэгж

### MSE A

17,574.53

нэгж

+24.31%

+3,436.59

нэгж

### MSE B

11,327.14

нэгж

-10.58%

-1,340.30

нэгж

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ

Монголын хөрөнгийн бирж ХК-д 2023 оны 12 сарын 28-ны байдлаар 173 ХК бүртгэлтэй байгаагаас 2.3% буюу 4 ХК нь 100 хувь төрийн өмчит, 6.4% буюу 11 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 91.3% нь буюу 158 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Худалдаа, үйлчилгээ	27
Геологи уул уурхай хүнд үйлдвэр	19
ХАА, Ойн аж ахуй	21
Хүнс, хөнгөн үйлдвэр	30
Барилга тээвэр	35
Санхүү, үл хөдлөх	35
Технологи	5
Нийтийн хангамж	1

Бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 19.1 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 7.1% буюу 1.36 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 92.9% буюу 17.75 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

## ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДИКАТОРУУД

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжаалагдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 11 их наяд 620 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4 их наяд 731 тэрбум төгрөг буюу 1.7 дахин өссөн үзүүлэлтэй гарчээ.



Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 41 437.42 нэгж, доод үзүүлэлт 34 218.33 нэгж, дундаж үзүүлэлт 36 777.17 нэгж байсан бөгөөд энэ нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 3 871.87 нэгжээр буюу 10.31 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Тайлант хугацаанд MSE-A индекс 17 574.53 нэгж хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 436.59 нэгжээр буюу 24.31 хувийн өсөлттэй байгаа бол MSE B индекс 11 327.14 нэгжид хүрч энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 340.30 нэгжээр буюу 10.58 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## ТОП-20 ИНДЕКСИЙН САГС


Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг 2023 онд дараах компаниуд бүрдүүлж байв.

	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР
1	APU	"АПУ" ХК
2	GLMT	"ГОЛОМТ БАНК" ХК
3	AARD	"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ " ХК
4	ERDN	"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХК
5	INV	"ИНВЕСКОР ББСБ" ХК
6	SBM	"ТӨРИЙН БАНК" ХК
7	GOV	"ГОВЬ" ХК
8	CUMN	"СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС" ХК
9	UID	"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК
10	TTL	"ТАВАНТОЛГОЙ" ХК
11	TUM	"ТҮМЭН ШУВУУТ" ХК
12	MFC	"МОНОС ХҮНС" ХК
13	SUU	"СҮҮ" ХК
14	MNDL	"МАНДАЛ ДААТГАЛ" ХК
15	BOGD	"БОГД БАНК" ХК
16	ADB	"АРД КРЕДИТ ББСБ" ХК
17	AIC	"АРД ДААТГАЛ" ХК
18	MNP	"МОНГОЛ ШУУДАН" ХК
19	SEND	"СЭНДЛИ ББСБ" ХК
20	BODI	"БОДЬ ДААТГАЛ" ХК



### ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2023 онд нийт 248 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 172 ХК-ийн 1 тэрбум 136 сая ширхэг хувьцааг 518.4 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 747 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг 63.5 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10 сая ширхэг нэгж эрхийг 6 тэрбум төгрөгөөр, компанийн өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.4 сая ширхэг бондыг 138.1 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 726 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.




Нийт арилжааны үнийн дүнгийн 71.41 хувь буюу 518.35 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 8.75 хувь буюу 63.49 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны арилжаа, 0.82 хувь буюу 5.91 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 19.02 хувь буюу 138.08 тэрбум төгрөгийг компанийн өрийн хэрэгслийн арилжаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 4.6 сая ширхэг үнэт цаасыг 3 тэрбум төгрөгөөр арилжсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 145 тэрбум төгрөгөөр буюу 25 хувиар өссөн үзүүлэлт болж байна.

### ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 248 удаагийн арилжаагаар 172 ХК-ийн 1 тэрбум 136 сая ширхэг хувьцааг 518.36 тэрбум төгрөгөөр арилжсан ба 66.42 хувь буюу 344.27 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 33.58 хувь буюу 174.08 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.



### ХУВЬЦААНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 344.27 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 660 сая ширхэг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсан

### ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 55.5 хувь буюу 96.61 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 43.72 хувь буюу 76.1 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 0.78 хувь буюу 1.36 тэрбум төгрөгийн гүйлгээг тендер арилжаа тус тус эзэлж байна.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 172 ХК-ийн 476.03 сая ширхэг буюу 174.08 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа арилжсан. Тайлант хугацаанд 169 ХК-ийн үнэт цаас арилжигдсанаас 63 компанийн үнэт цаасны ханш өсч, 68 компанийн үнэт цаасны ханш буурч, 38 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс "Мон бийф" ХК, "Жуулчин дюти фрий" ХК болон "Хөвсгөл усан зам" ХК-иудын үнэт цаас тус тус хасагдсан.



## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 63.49 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 746.59 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 8.75 хувийг эзэлж байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Тайлант хугацаанд “Үндэсний хувьчлалын сан” болон “Мандал ирээдүйн өсөлт” хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 10.02 сая ширхэг нэгж эрхийг 5.91 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 0.82 хувийг эзэлж байна.

## БАГЦЫН АРИЛЖАА

Тайлант хугацаанд 76.10 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 114.22 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 43.72 хувийг эзэлж байна. Үүнд өндөр дүнгээр арилжаалагдсан эхний гурван хувьцаат компани нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК, “Ард Кредит ББСБ” ХК, “Хорин Хоёрдугаар Бааз” ХК байна.

## КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 138.08 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.380 сая ширхэг өрийн хэрэгсэл арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 15.81 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд компанийн бондын анхдагч зах зээлд нийт 1,075,000 ширхэг, 107.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл арилжигдсан байна. Үүнд:

- “Сэндли ББСБ” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 19.2 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай, 85,000 ширхэг “Сэндли бонд”-ыг нийт 8.5 тэрбум төгрөгөөр;
- “Инвекор ББСБ” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 300,000 ширхэг “Инвекор-2.0” бондын транч-3, 4,5-ыг нийт 30 тэрбум төгрөгөөр;
- “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18.5 хувийн хүүтэй, 18 сарын хугацаатай, 80,000 ширхэг “Бид бонд”-ыг нийт 8 тэрбум төгрөгөөр;
- “Ашид капитал ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 200,000 ширхэг “Симпл I бонд”-ыг нийт 20 тэрбум төгрөгөөр;
- “ЛэндМН ББСБ” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай, 90,000 ширхэг “Лэнд бонд”-ыг нийт 9 тэрбум төгрөгөөр;
- “Ашид капитал ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17.5 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 150,000 ширхэг “Симпл II бонд”-ыг нийт 15 тэрбум төгрөгөөр;
- “Хаан банк” ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 16 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай, 170,000 ширхэг “Ногоон бонд”-ыг нийт 17 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд амжилттай арилжсан байна.

## БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар I ангилалд 27, II ангилалд 46, III ангилалд 100 хувьцаат компани багтаж байна.

**ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ /сая/	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН /тэрбум/
БОГД БАНК	68.73	ИНВЕСКОР ББСБ	33.47
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	51.47	ХААН БАНК	18.84
ЛЭНДМН ББСБ	25.43	АПУ	16.27
ПРЕМИУМ НЕКСУС	25.25	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	15.13
СЭНДЛИ БСББ	24.16	ГОЛОМТ БАНК	13.05
МАНДАЛ ДААТГАЛ	22.58	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	8.65
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	17.16	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	7.57
АРД КРЕДИТ ББСБ	16.65	БОГД БАНК	7.03
ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	16.41	МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ	5.53
ХААН БАНК	16.13	ГОВЬ	4.73
ГОВЬ	15.63	ПРЕМИУМ НЕКСУС	4.71
ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	14.19	ТАВАН ТОЛГОЙ	4.57
МОНОС ХҮНС	14.11	СЭНДЛИ БСББ	4.22
АПУ	14.05	АТАР-ӨРГӨӨ	4.01
ГОЛОМТ БАНК	11.50	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	2.39
РЕМИКОН	9.64	ТАЛХЧИХЭР	2.27
МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	7.95	АРД КРЕДИТ ББСБ	1.95
МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ	6.25	ТӨРИЙН БАНК	1.65
ИНВЕСКОР ББСБ	5.84	АРД ДААТГАЛ	1.60
ДАРХАН НЭХИЙ	5.79	ТҮМЭН ШУВУУТ	1.53
БОДЬ ДААТГАЛ	4.97	МОНОС ХҮНС	1.53
ТҮМЭН ШУВУУТ	4.54	МАНДАЛ ДААТГАЛ	1.52
ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	3.77	МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ	1.45
ТӨРИЙН БАНК	2.93	МОНГОЛ ШУУДАН	1.17
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	2.71	ЛЭНДМН ББСБ	1.06
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	2.62	КРИПТО ҮНДЭСТЭН	1.02
МОНГОЛ БАЗАЛЫТ	2.54	СҮҮ	0.97
СҮҮ	2.46	ХАС БАНК	0.92
АРД ДААТГАЛ	1.89	ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР	0.89
ХАС БАНК	1.52	ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	0.63

**ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	ӨӨРЧЛӨЛТ			
	2022.12.30	2023.12.28	ҮНИЙН ДҮН	ХУВЬ
ӨНДӨРХААН	2,600.00	24,100.00	21,500.00	826.92
ЭРЭЭНЦАВ	1,400.00	9,180.00	7,780.00	555.71
ХИШИГ УУЛ	591.00	2,800.00	2,209.00	373.77
ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	230.00	971.00	741.00	322.17
ТАВИЛГА	2,412.00	9,725.00	7,313.00	303.19
УЛААНСАН	1,100.00	3,737.00	2,637.00	239.73
ЖИДАКС	96.00	310.00	214.00	222.92
ТЕХНИК ИМПОРТ	12,000.00	31,340.00	19,340.00	161.17
ХҮРД	45,720.00	115,500.00	69,780.00	152.62
ТАВАН ТОЛГОЙ	8,105.00	17,810.00	9,705.00	119.74
СОНСГОЛОН БАРМАТ	1,100.00	2,354.00	1,254.00	114.00
МОНГОЛ ДИЗЕЛЬ	3,333.00	6,900.00	3,567.00	107.02
МОНГОЛ КЕРАМИК	1,110.00	2,248.00	1,138.00	102.52
МОНГОЛ НЭХМЭЛ	5,060.00	10,120.00	5,060.00	100.00
ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	165.00	328.00	163.00	98.79
МАНДАЛ ГОВЬ ИМПЭКС	710.00	1,325.00	615.00	86.62
СОР	390.00	709.00	319.00	81.79
ТЭЭВЭР ДАРХАН	8,275.00	14,990.00	6,715.00	81.15
ЛЭНДМН ББСБ	30.89	53.96	23.07	74.68
МОГОЙН ГОЛ	9,200.00	16,000.00	6,800.00	73.91

**ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	ӨӨРЧЛӨЛТ			
	2022.12.30	2023.12.28	ҮНИЙН ДҮН	ХУВЬ
ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС	44.84	10.22	(34.62)	(77.21)
АТАР-ӨРГӨӨ	68,000.00	33,000.00	(35,000.00)	(51.47)
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	200.00	100.00	(100.00)	(50.00)
ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	2,733.00	1,400.00	(1,333.00)	(48.77)
ЖЕНКО ТУР БЮРО	52.00	29.26	(22.74)	(43.73)
АВТО ИМПЕКС	2,680.00	1,552.00	(1,128.00)	(42.09)
ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП	16,900.00	10,000.00	(6,900.00)	(40.83)
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	499.90	302.03	(197.87)	(39.58)
МҮДИКС	4,675.00	3,000.00	(1,675.00)	(35.83)
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	659.00	461.08	(197.92)	(30.03)
ГОЛОМТ БАНК	1,274.00	906.74	(367.26)	(28.83)
БАГАНУУР	1,098.00	788.00	(310.00)	(28.23)
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	4,880.00	3,506.00	(1,374.00)	(28.16)
ХАЙ БИ ОЙЛ	33.00	23.77	(9.23)	(27.97)
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	4,144.00	3,009.00	(1,135.00)	(27.39)
СҮҮ	473.25	345.71	(127.54)	(26.95)
ОЛЛОО	19.02	14.00	(5.02)	(26.39)
ГУТАЛ	55,050.00	41,240.00	(13,810.00)	(25.09)
УБ-БУК	380.10	290.00	(90.10)	(23.70)
АДУУН ЧУЛУУН	793.00	620.00	(173.00)	(21.82)

# УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ


## 2023 ОНД МХБ-ЭЭР АРИЛЖИГДСАН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ТОЙМ

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хүрээнд нүүрсний арилжаанд оролцогч талууд болох нүүрс худалдах болон худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийг оролцуулсан туршилтын цахим дуудлага арилжааг 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжааг нээлттэй, ил тод, шударга зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтох боломжийг бүрдүүлснээр өнгөрсөн 1 жилийн хугацаанд худалдагч компаниуд болох “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Хангад Эксплорэйшн” ХХК, “Тавантолгой” ХК, “Андын Илч” ХХК, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан нийт 15.6 сая тонн нүүрс, төмрийн хүдэр болон баяжмалыг 7.5 их наяд төгрөгөөр буюу 2.2 тэрбум ам.доллараар арилжаалсан байна. 2023 онд нийт 344 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна.

## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА

2023 онд нийт 299 удаагийн арилжаа амжилттай явагдаж 15,615,050 тонн уул уурхайн бүтээгдэхүүн арилжигдсан бөгөөд нүүрсний арилжаагаар 14,937,600 тонн нүүрс, төмрийн арилжаагаар 677,450 тонн төмрийн хүдэр, төмрийн баяжмал тус тус арилжигдсан байна. Нийт арилжааны 95.7 хувийг нүүрсний арилжаа, 4.3 хувийг төмрийн хүдэр болон төмрийн баяжмалын арилжаа тус тус эзэлж байна.




## НҮҮРСНИЙ АРИЛЖАА


2023 онд нийт 204 удаагийн нүүрсний дуудлага арилжаа явагдаж 14.9 сая тонн нүүрсийг 7 их наяд 345.2 тэрбум төгрөгөөр буюу 2.15 тэрбум ам.доллараар арилжсан байна. Дуудлага худалдаагаар арилжсан нүүрсний үнийн өсөлтийн дундаж 8.5 хувь байна. 2023 онд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан нүүрсний үнийн өсөлтөөс нийт 523.66 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна. Тайлант хугацаанд 1 удаагийн нүүрсний арилжаагаар дунджаар 73.2 мянган тонн нүүрсийг 36.0 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /тэрбум/
1	Баяжуулсан коксжих нүүрс	1,472,000	₮ 949.96
2	Дэгдэмхий бодис дунд коксжих нүүрс	9,036,800	₮ 4,939.91
3	Баяжуулсан сул коксжих нүүрс	140,800	₮ 68.15
4	1/3 коксжих нүүрс	2,937,600	₮ 1,074.88
5	Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс	153,600	₮ 36.57
6	Эрчим хүчний нүүрс	1,075,200	₮ 238.56
7	Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрсний	108,800	₮ 35.79
8	Чийг багатай хүрэн нүүрс	12,800	₮ 1.35
<b>НИЙТ</b>		<b>14,937,600</b>	<b>₮ 7,345.19</b>

Нийт нүүрсний арилжааны үнийн дүнгийн 67.25 хувь буюу 4 их наяд 939.92 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дунд коксжих нүүрсний арилжаа, 14.63 хувь буюу 1 их наяд 74.88 тэрбум төгрөгийг 1/3 коксжих нүүрсний арилжаа, 12.93 хувь буюу 949.97 тэрбум төгрөгийг Баяжуулсан коксжих нүүрсний арилжаа, 3.25 хувь буюу 238.56 тэрбум төгрөгийг Эрчим хүчний нүүрсний арилжаа, 0.93 хувь буюу 68.15 тэрбум төгрөгийг Баяжуулсан сул коксжих нүүрсний арилжаа, 0.5 хувь буюу 36.57 тэрбум төгрөгийг Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрсний арилжаа, 0.5 хувь буюу 35.79 тэрбум төгрөгийг Дэгдэмхий бодис дундаас их хийн нүүрсний арилжаа, 0.02 хувь буюу 1.35 тэрбум төгрөгийн Чийг багатай хүрэн нүүрсний арилжаа тус тус эзэлж байна.



Нүүрсний арилжааны нийт үнийн дүнгийн 59.45 хувь буюу 4 их наяд 366.36 тэрбум төгрөгийн арилжааг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 26.18 хувь буюу 1 их наяд 923.8 тэрбум төгрөгийн арилжааг “Тавантолгой” ХК, 13.43 хувь буюу 986.54 тэрбум төгрөгийн арилжааг “Энержи ресурс” ХХК, 0.93 хувь буюу 68.15 тэрбум төгрөгийн арилжааг “Хангад Эксплорэйшн” ХХК, 0.02 хувь буюу 1.35 тэрбум төгрөгийн арилжааг “Андын Илч” ХХК тус тус арилжаалсан байна.




2023 онд нийт 204 нүүрсний арилжаа амжилттай явагдсан бөгөөд 12 дугаар сард хамгийн их буюу 33 удаагийн нүүрсний арилжаа хийгдсэн байна. Үүнд:

Арилжаа явагдсан сар	Арилжааны тоо	Хэмжээ /тонн/	Үнийн дүн /тэрбум/
1-р сар	1	12,800	₮ 8.43
2-р сар	4	19,200	₮ 122.37
3-р сар	11	588,800	₮ 305.55
4-р сар	10	390,400	₮ 210.16
5-р сар	9	358,400	₮ 122.1
6-р сар	19	1,568,000	₮ 545.4
7-р сар	5	153,600	₮ 69.24
8-р сар	22	1,049,600	₮ 480.3
9-р сар	27	3,155,200	₮ 1,473.24
10-р сар	32	2,387,200	₮ 1,141.56
11-р сар	31	1,651,200	₮ 942.37
12-р сар	33	3,430,400	₮ 1,924.5

## ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛЫН АРИЛЖАА


Улсын Их Хурлаас Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль баталж 2023 оны 6 дугаар сарын 30 – ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. “Монголын хөрөнгийн бирж” ХК – ийн ТУЗ – ийн 2023 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор “Төмрийн хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоох, мөрдүүлэх журам”-ыг баталсан бөгөөд “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК худалдагчаар бүртгүүлж, гэрээ байгуулснаар тус компаниудын захиалгыг хүлээн авч, 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр анхны төмрийн хүдэр, баяжмалын арилжааг амжилттай зохион байгуулсан.



2023 онд арилжигдсан төмрийн хүдэр, баяжмал

2023 онд нийт 95 удаагийн арилжаагаар 677.4 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 196.2 тэрбум төгрөгөөр буюу 57.5 сая ам.доллараар арилжсан. Үүнд:


448,700 тонн буюу 134.72 тэрбум төгрөгийн төмрийн баяжмал, 228,750 тонн буюу 61.48 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр тус тус арилжигдсан байна.



Тодруулбал: Fe – 65%-ийн төмрийн баяжмал 210,000 тонн буюу 71.32 тэрбум төгрөгийн, Fe – 58%-ийн төмрийн баяжмал 238,700 тонн буюу 63.4 тэрбум төгрөгийн, Fe-52%-ийн төмрийн хүдэр 228,750 тонн буюу 61.48 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн байна. Үүнд:





- 9 дүгээр сард 9 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 100,600 тонн буюу 33.59 тэрбум төгрөгийн арилжаа,
- 10 дугаар сард 32 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 266,800 тонн буюу 77.01 тэрбум төгрөгийн арилжаа,
- 11 дүгээр сард 31 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 184,650 тонн буюу 50.27 тэрбум төгрөгийн арилжаа,
- 12 дугаар сард 23 удаагийн төмрийн хүдэр, баяжмалын арилжаа явагдаж 125,400 тонн буюу 35.33 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийсэн.

2023 онд худалдагч компаниуд дуудлага арилжаагаар арилжигдсан төмрийн хүдэр, баяжмалын үнийн өсөлтөөс нийт 11.91 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олсон байна.






## 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 2023



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/54/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: **Ц.Наранчимэг**  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: **П.Чанцалдулам**  
Утас: 261885 Цахим хаяг: [chantsaldulamj@audit.gov.mn](mailto:chantsaldulamj@audit.gov.mn)  
Ахлах аудитор: **Э.Энхбаатар**  
Утас: 261628 Цахим хаяг: [enkhbaatare@audit.gov.mn](mailto:enkhbaatare@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит ХХК  
-ийн захирал: **С.Тунгалаг**  
Утас: 70001778

Улаанбаатар хот  
2024 он



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/781

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦОГТБАЯР  
ТАНАА

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс урсгал зардалд зарцуулсан, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 461.7 сая төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.11-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын "төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох шийдвэр гаргасан байна.

0001951657

Санхүүгийн зохицуулах хорооны “Нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай” 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 690 дугаар тогтоолоор нийтэд санал болгон нэмж гаргаж буй нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,157,603 /Нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав/ ширхэг хувьцааг бүртгэн тус компанийн нийт хувьцааг 350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин есөн) ширхэг байхаар зөвшөөрлийг олгожээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь анхдагч арилжааг 2022 оны 12 дугаар сарын 26-наас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд анхдагч арилжааг амжилттай зохион байгуулж, Хоёрдогч арилжааг 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр эхлүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолоор нэг бүр нь 100 /нэг зуун/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 ширхэг энгийн хувьцаатай буюу 11,915.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 35,046.4 сая төгрөгөөр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг компанийн дүрмээр баталсан байна.

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2022 оны цэвэр ашиг болох 646.2 сая төгрөгөөс ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Монголын хөрөнгийн бирж ХК нь 2022 оны өөрийн хөрөнгийн дүнгийн 3 хувиар буюу 635.8 сая төгрөгийн уул уурхайн биржийн эрсдэлийн санг анх удаа байгуулж, Голомт банканд байршуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар тогтоолоор компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг 91.0 хувийн хэрэгжилттэй, “Хангалттай”, 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Санхүүгийн үйл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэсэн байна.

Компани нь 2023 онд 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил, 117 арга хэмжээг төлөвлөсөн ба үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт аудитын явцад гараагүй байна.

Монгол Улсын Сангийн яамны Санхүүгийн хяналт удирдлагын газраас Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан 3 үндсэн зорилгын хүрээнд 14 зорилтыг хэрэгжүүлэхээр 33 багц ажил, 117 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 80.3 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн нь өмнөх оны хяналт шинжилгээ үнэлгээний гүйцэтгэлийн үнэлгээнээс 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тус хяналт шинжилгээ үнэлгээгээр 12 зөвлөмж хүргүүлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,731,709,823.19	902,582,814,516.91
1.1.2	Дансны авлага	504,659,308.87	1,868,454,950.77
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	822,948.07	1,457,509.01
1.1.4	Бусад авлага	-	149,471,451.41
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	33,650,495.17	36,053,729.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,775,744.35	204,642,999.30
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,296,778,319.65</b>	<b>904,842,895,157.05</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,536,483,495.31	5,453,061,929.98
1.2.2	Биет бус хөрөнгө	17,648,438,922.95	16,998,953,543.12
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>23,184,922,418.26</b>	<b>22,452,015,473.10</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,481,700,737.91</b>	<b>927,294,910,630.15</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	793,176,221.30	265,821,383.36
2.1.1.2	Цалингийн өглөг	-	612,117.37
2.1.1.3	Татварын өглөг	190,085,198.35	341,303,910.22
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	15,396,128.32	17,955,656.95
2.1.1.9	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	-	880,962,845,181.82
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>998,657,547.97</b>	<b>881,588,538,249.72</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	635,862,600.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	<b>990,846,139.66</b>	<b>990,698,992.92</b>
2.1.2.4	<b>Бусад урт хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>990,846,139.66</b>	<b>1,626,561,592.92</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,989,503,687.63</b>	<b>883,215,099,842.64</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>35,046,353,900.00</b>
	Өмч:		
2.3.1	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	11,915,760,300.00
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,021,146,332.29
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(20,105,864,784.03)	(11,434,011,346.80)
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>23,492,197,050.28</b>	<b>44,079,810,787.51</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>25,481,700,737.91</b>	<b>927,294,910,630.15</b>



**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
<b>1</b>	<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>4,241,344,850.62</b>	<b>12,147,031,303.89</b>
1.1	Брокер, диллерийн үйл ажиллагааны орлого	4,241,344,850.62	-
1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	-	-
1.3	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	-	12,147,031,303.89
1.4	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	-	-
<b>2</b>	<b>Түрээсийн орлого</b>		
<b>3</b>	<b>Хүүний орлого</b>	-	4,562,440,335.78
<b>4</b>	<b>Ногдол ашгийн орлого</b>	-	-
4.1	Хувьцааны ногдол ашиг		
4.2	Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг		
<b>5</b>	<b>Эрхийн шимтгэлийн орлого</b>	-	-
<b>6</b>	<b>Бусад орлого</b>	27,070,762.46	13,170,675.00
<b>7</b>	<b>Борлуулалт маркетингийн зардал</b>	-	186,062,107.06
<b>8</b>	<b>Ерөнхий ба удирдлагын зардал</b>	3,557,629,057.47	5,992,598,429.63
<b>9</b>	<b>Санхүүгийн зардал</b>	-	-
<b>10</b>	<b>Бусад зардал</b>	71,765,222.02	19,748,469.36
<b>11</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/</b>	130,867,477.80	(186,717,492.52)
<b>12</b>	<b>Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/</b>	(141,003.17)	-
<b>13</b>	<b>Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/</b>	-	-
<b>14</b>	<b>Бусад ашиг /алдагдал/</b>	-	-
<b>15</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>769,747,808.22</b>	<b>10,337,515,816.10</b>
<b>16</b>	<b>Орлогын татварын зардал</b>	123,519,584.56	1,029,799,778.87
<b>17</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>646,228,223.66</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>18</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/</b>	-	-
<b>19</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>646,228,223.66</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>20</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>20,008,784,115.62</b>	-
20.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	20,008,784,115.62	-
20.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
20.3	Бусад олз /гарз/	-	-
<b>21</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>20,655,012,339.28</b>	<b>9,307,716,037.23</b>
<b>22</b>	<b>Татварын өглөг</b>	-	-

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	-	-	<b>12,362,200.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	-	-	<b>12,362,200.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	20,008,784,100.00
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	-	-	<b>20,021,146,332.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	-	-	<b>20,021,146,332.29</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	11,915,760,300.00	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>35,046,353,900.00</b>	-	-	<b>20,021,146,332.29</b>

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН** (төгрөгөөр)

Үзүүлэлт	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>446,321,902.02</b>	<b>(19,151,772,700.00)</b>	<b>4,437,505,000.00</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(1,600,320,300.00)	<b>(1,600,320,300.00)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	<b>446,321,902.02</b>	<b>(20,752,093,000.00)</b>	<b>2,837,184,700.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	646,228,223.66	<b>646,228,223.66</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	<b>20,008,784,100.00</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>446,321,902.02</b>	<b>(20,105,864,784.03)</b>	<b>23,492,197,050.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(635,862,600.00)	<b>(635,862,600.00)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	<b>446,321,902.02</b>	<b>(20,741,727,384.03)</b>	<b>22,856,334,450.28</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	9,307,716,037.23	<b>9,307,716,037.23</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	<b>11,915,760,300.00</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>446,321,902.02</b>	<b>(11,434,011,346.80)</b>	<b>44,079,810,787.51</b>

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,914,481,245.55</b>	<b>1,441,824,632,647.89</b>
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	3,735,454,914.86	11,595,182,149.63
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,684,791.01	6,128,434.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
1.1.7	Хүлээн авсан хүүний орлого	-	4,413,827,379.90
1.1.8	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
1.1.9	Бусад мөнгөн орлого	177,341,539.68	1,425,809,494,684.36
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>4,619,870,426.48</b>	<b>544,905,224,391.89</b>
1.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	238,000,000.00
1.2.2	Ажиллагчдад төлсөн	876,401,679.77	1,778,266,221.02
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	259,137,491.60	512,421,844.47
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	35,755,782.00	41,110,050.00
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	65,253,743.16	111,522,685.60
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,674,470.00	1,758,400.00
1.2.7	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	473,654,111.92	2,058,142,678.97
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	-	5,000,000.00
1.2.10	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжинд төлсөн	-	566,128,324.18
1.2.11	Бусад мөнгөн зарлага	2,901,993,148.03	539,592,874,187.65
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(705,389,180.93)</b>	<b>896,919,408,256.00</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2022	12/31/2023
2.1.4	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>423,392,511.67</b>	<b>575,344,268.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	286,663,700.00	347,651,580.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	136,728,811.67	227,692,688.00
2.2.3	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусдад олгосон зээл, болон урьдчилгаа	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(423,392,511.67)</b>	<b>(575,344,268.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	11,915,759,800.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	11,915,759,800.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад мөнгөн орлого	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
3.2.1	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	-	-
3.2.3	Хувьцаа буцааж худалдан авахад төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад мөнгөн зарлага	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	11,915,759,800.00
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>131,127,879.87</b>	<b>(7,408,719,094.28)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(997,653,812.73)</b>	<b>900,851,104,693.72</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,729,363,635.92</b>	<b>1,731,709,823.19</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,731,709,823.19</b>	<b>902,582,814,516.91</b>



**МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ**

Монголын Хөрөнгийн Бирж

**Хаяг:** Сүхбаатарын талбай-3,  
Улаанбаатар 15160, Монгол улс

**Утас:** (+976)-11-313747

**Факс:** (+976)-11-325170

**Веб хуудас:** [www.mse.mn](http://www.mse.mn)

**И-мэйл:** [info@mse.mn](mailto:info@mse.mn)